

БАТЛАВ
ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
АЭРДЭНЭСАЙХАН



ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМАНД “ГАМШГААС ХАМГААЛАХ
САН/БЭЛЭН БАЙДЛЫН ИЖ БҮРЭН ҮЗЛЭГ СУРГАЛТ, БАЙГАЛИЙН ГАМШИГ
ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” АЖЛЫН ГЭРЭЭ

2023.05.22.

№ ДУГАЦДСЗДТГ/202304023

Хараат

Энэхүү гэрээг нэг талаас 9033599 регистрийн дугаартай, Монгол Улсын Хуулийн этгээд болох Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын ЗДТГ (цаашид “захиалагч” гэх) нөгөө талаас “Бошиго арвижих” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) (хамтад нь талууд гэх) нар дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдуулан захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Нэг. Гэрээний агуулга

Энэхүү гэрээгээр нийлүүлэгч нь захиалагчид биет байдлын болон чанарын доголдолгүй, стандарт, зруул ахуйн шаардлага хангасан барааг гэрээнд заасан нөхцлөөр нийлүүлэх, захиалагч барааны үнийг урьдчилан төлөхтэй холбогдсон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Дор дурьдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно. /цаашид гэрээний баримт бичиг гэх/ Үүнд:

- 1.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 1.2 Бусад шаардлагатай баримт бичиг
- 1.3 Гэрээний тусгай нөхцөл
- 1.4 Гэрээний ерөнхий нөхцөл
- 1.5 Техникийн тодорхойлолт
- 1.6 Зураг
- 1.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь
- 1.8 Санхүүжилтийн хуваарь

Хоёр. Барааны нэр төрөл, үнэ

2.1. Нийлүүлэх барааны нэр төрөл

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг сургалт, байгалийн гамшиг, халварт өвчинеөс урьдчилан сэргийлэх үеийн хувцас, хэрэгсэл

2.2. Гэрээгээр нийлүүлэх барааны нийт үнэ нь 15,000,000 /арван таван сая/ төгрөг байна.

2.3. Худалдан авагч нь ёөрт хэрэгтэй барааны захиалгаа нийлүүлэгчид өгч баталгаажуулна. Нийлүүлэгч нь тогтсон хугацаанд барааг нийлүүлнэ.

3.1. Нийлүүлэгч талын нийлүүлэх бараа бүтээгдэхүүний үнэ нь нэмэгдсэн өргийн албан татварыг оролцуулсан бөгөөд тээвэрлэлт орсон болно.

3.2. Захиалагч нь нийлүүлэгчид барааны үнийн урьдчилгаа 70%, хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийн 30% -ийг төлнө.

3.3. Захиалагч нь барааны төлбөрийг "Бошиго арвижих" ХХК-ний ХААН банкин дах төгрөгийн 5040423331 тоот харилцах дансанд шилжүүлнэ.

3.4. Тухайн зарагдсан барааны төлбөр тооцог тогтоосон хугацаанд барагдуулаагүй тохиолдолд хийгдэх ёстай үнийн дүнгээс хоногийн 0,5 % алданги тооцно.

Дөрөв. Нийлүүлэгч талын эрх, үүрэг

4.1. Барааг захиалагчаас ирүүлсэн захиалгын дагуу нэр, төрөл, тоо хэмжээгэр нь хүлээлгэн өгөх үүрэгтэй.

4.2. Барааг хүлээлгэн өгөх явцад чанарын доголдолтой зүйл гарсан тохиолдолд доголдолтой барааг хүлээн авах буюу сольж өгөх үүрэгтэй.

4.3. Гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

4.4. Нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний дагалдах баримтыг бүрдүүлэн захиалагчид өгөх үүрэгтэй

4.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Тав. Захиалагчийн эрх, үүрэг

5.1. Нийлүүлж байгаа бүтээгдэхүүнийг хүлээлт үүсгэхгүйгээр түргэн шуурхай хүлээн авч, дагалдах баримтанд гарын үсэг зурж баталгаажуулах

5.2. Барааг хүлээн аваходаа барааны чанар, төрөл, тоог сайтар шалгаж хүлээн авах үүрэгтэй

5.3. Барааг хүлээн авах үед чанарын доголдол болон гэмтэлтэй бараа гарсан тохиолдолд уг барааг буцаах буюу солиулах эрхтэй

5.4. Худалдагчаас чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан барааг нийлүүлэхийг шаардах эрхтэй

Зургаа. Талуудын үүрэг хариуцлага

6.1. Гэрээг зөрчсөн тал нөгөө талдаа олох байсан орлогыг оролцуулан бүх холбогдох хохирлыг хуулийн дагуу төлнө.

6.2. Худалдагсан хэрэнгийн үнэ тухайн үеийн ижил чанар, төрлийн хэрэнгийн зах зээлийн үнээс илт зөрүүтэй бол талууд хэрэнгийн үнийн зөрүүг арилгах үүрэгтэй.

6.3. Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөнөөс аль нэг талд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, нөхөн төлнө. Хохирол учирсан тал батлана.

6.4. Энэ гэрээний үйлчлэх хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлэхээс нэг талын журмаар үндэслэлгүйгээр татгалзсан буруутай тал нөгөө талд үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх торгууль төлнө.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үйлмээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

7.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн тухай талууд нэн даруй нэг, нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

Найм. Маргааныг шийдвэрлэх

8.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцо замаар шийдвэрлэнэ.

8.2. Талууд тохиолцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүх, арбитраар шийдвэрлүүлнэ.

Ес. Гэрээний үйлчлэх хугацаа, дуусгавар болох, цуцлах

9.1. Гэрээний эхлэх хугацаа: 2023 оны 05 дугаар сарын 23
Гэрээний дуусах хугацаа: 2023 оны 06 дугаар сарын 30

9.2. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг даран, баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

9.3. Нийлүүлэгч тал чанаргүй бараа нийлүүлсэн тохиолдолд захиалагч тал гэрээг цуцлах эрхтэй.

9.4. Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээнд тусгагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна. Гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба энэхүү өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУДЫН ХЯАГ:

ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын дарга

..... Ш.Мөнх-Оргил

ХАЯГ: Дундговь аймаг, Цагаандэлгэр сум
1 дүгээр баг

УТАС: 95971666

TU31984 9002599 0820020006

НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

..... гишүүн

..... Э.Баярцэцэг

ХАЯГ : Улаанбаатар хот, Баянзүрх 22-р хороо

УТАС: 88108959